


2016 ЖИЛИЙН ТАЙЛАН





АГУУЛГА

1 ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм зорилго

Компанийн түүх

5 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн бүтэц

Төлөөлөн удирдах зөвлөл

9 ГОЛЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

“МОНГОЛ ШУУДАН” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдав

“МОНГОЛ-ЛОНДОНГИЙН БИЗНЕС ФОРУМ” болж өнгөрлөө

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлаар Х.Алтайг томиллоо

“MIT” систем кастодиан банкны үйл ажиллагааг дэмжин ажиллахад бэлэн боллоо

15 ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

Дэлхийн эдийн засгийн төлөв

Монгол Улсын макро эдийн засаг

Гадаад сектор

23 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Санхүүгийн салбарын бүтэц

Үнэт цаасны зах зээлийн статистик

47 САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүүгийн байдлын тайлан

Дэлгэрэнгүй орлогын тайлан


Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мөнгөн гүйлгээний тайлан



ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зах зээл дэх хөрөнгийн хуримтлалыг хямд өртөгтэйгөөр урт хугацаанд зуучлан хүргэх үүрэг бүхий үнэт цаасны сонгодог зах зээлийг бий болгон төлөвшүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахад оршино.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм уншигч танаа,
“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын хувиар эрхэм уншигч таны энэ өдрийн амар амгаланг айлтгаж, 2016 оны жилийн тайлангаа үүгээр хүргэн танилцуулж байна. Өнгөрөгч 2016 он нь хөрөнгийн зах зээлд өөрчлөлт шинэчлэлийн ажлыг дахин эхлүүлсэн амжилт бүтээлээр дүүрэн он жил байлаа. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлаар 2011-2014 онд ажиллаж байсан миний бие 2016 оны 9 сараас дахин томилогдож, үнэт цаас гаргагчид, хөрөнгө оруулагчид та бүхэнтэй хамтран ажиллах болсондоо баяртай байна.

Хөрөнгийн зах зээлийн арилжааны идэвх болон зах зээлийн хөгжил нь макро эдийн засгийн төлөв байдалтай нягт салшгүй холбоотой бөгөөд эрчээ авч эхэлж буй эдийн засгийн өсөлт, үүнтэй уялдан арилжааны идэвх нэмэгдэхэд бэлтгэн, олон улсын хөрөнгө оруулагчдын шаардаж буй хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын болон дэд бүтцийн таатай орчныг бий болгож, бэлтгэл хангах явдал нь нэн тэргүүний ач холбогдолтой билээ. Олон улсын жишигт нийцсэн техник технологи, төлбөр тооцооны горимыг 2012 онд нэвтрүүлж, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга 2013 онд батлагдсанаар Монголын хөрөнгийн зах зээл хөгжлийн шинэ шатанд гарсан хэдий ч төлбөр тооцооны системийг 2015 оноос эргэн урьдчилсан төлбөрт системд оруулсан нь зах зээлд гарсан ахиц дэвшлээс ухарсан алхам болсон хэмээн зах зээлийн мэргэжилтнүүд болон олон улсын хөрөнгө оруулагчид үзэж байна.

Миний бие гүйцэтгэх захирлаар эргэн томилогдсоноос хойш хамгийн түрүүнд хийхээр зорьж буй ажлууд нь мэргэжлийн оролцогч байгууллагуудтай хамтран зах зээлийн төлбөр тооцооны системийг олон улсын жишигт нийцсэн T+2 горимд шилжүүлэх, төлбөр тооцооны ажиллагаа дахь эрсдэлийг бууруулах зорилгоор “төлбөрийн эсрэг нийлүүлэлт” зарчмыг нэвтрүүлэх, Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгийн биржид хувьцаагаа гаргасан компаниудыг дотоодын хөрөнгийн биржээр арилжаалах, ард иргэд эдгээр компаниудын хувьцааг эзэмшиж, ашиг шимийг нь хүртэх боломжийг бий болгох зорилгоор үнэт цаасны давхар бүртгэлийн ажиллагааг нэвтрүүлэх ажлууд бөгөөд эдгээр чиглэлүүдээр холбогдох дүрэм журмуудыг боловсруулан чамлалтгүй ахиц дэвшил гарган ажиллаж байгааг дуулгахад таатай байна.

Мөн 2016 онд төрийн өмчит “Монгол шуудан” ХК нь 6 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжааг амжилттай зохион байгуулснаар төрийн өмчийн хувьчлалыг олон нийтэд нээлттэй, ил тод явуулж болдгийн жишээ болсон төдийгүй тус компанийн хувьцааг худалдан авахаар 2 дахин их буюу 12 тэрбум төгрөгийн захиалга ирсэн нь хөрөнгө оруулагчдын идэвх нэмэгдэж байгаагийн дохио болж байна. Иймд ирэх 2017 онд ч бид компанийн хувьцаа, бондын арилжааг идэвхжүүлэх, зах зээлд шинэ бүтээгдэхүүн гаргах чиглэлээр түлхүү анхаарч ажиллах болно.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь санхүүгийн зах зээл дэх хөрөнгийн хуримтлалыг хямд өртөгтэйгөөр урт хугацаанд зуучлан хүргэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах эрхэм зорилгын дор ажиллаж байгаа бөгөөд хөрөнгийн зах зээлд ажиллаж буй нийт мэргэжлийн байгууллагууд, мэргэжилтнүүд бидний өмнө асар их хүлээлт, ажил байна.

Монголын хөрөнгийн зах зээлд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, өмнөх зорилтуудаа амжилттай хэрэгжүүлэхэд мэргэжлийн байгууллагууд болон зах зээлийн оролцогчид нягт хамтран ажиллаж, бодит үр дүнд хүрнэ гэдэгт итгэлтэй байгаа бөгөөд хамтран ажилладаг зах зээлийн оролцогчид, үнэт цаас гаргагчид болон хөрөнгө оруулагчид та бүхэнд өндөр амжилт хүсье.



Хүндэтгэсэн,



Х.АЛТАЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ТҮҮХЭН ТОВЧООН






КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



КОМПАНИЙН БҮТЭЦ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн гишүүд нь компанийн хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлэгчийн шийдвэр буюу Сангийн сайдын тушаалаар томилогддог бөгөөд 6 хараат гишүүн, 3 хараат бус гишүүн, нийт 9 гишүүдийн бүрэлдэхүүнтэй ажилладаг. Компанийн тухай хуулийн дагуу ТУЗ нь дэргэдээ:

- Аудитын хороо,
- Нэр дэвшүүлэх хороо,
- Цалин урамшууллын хороог ажиллуулдаг ба хороо тус бүрийн 2/3 нь хараат бус гишүүдээс бүрддэг.

Компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ нь сард нэг удаа ээлжит хурлыг зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зарлан хуралддаг.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Б.Нямаа	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	Н.Мөнхбат	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Д.Сарангуа	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн /Хараат бус/
Б.Даажамба	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Б.Сүх-Очир	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	П.Баянсан	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн /Хараат бус/
Д.Болормаа	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Н.Энхбаяр	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	-	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн /Хараат бус/

АУДИТЫН ХОРОО		НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО		ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО	
П.Баянсан	Аудитын хорооны дарга	Б.Сүх-Очир	Нэр дэвшүүлэх хорооны дарга	Д.Сарангуа	Цалин, урамшууллын хорооны дарга
	Аудитын хорооны гишүүн	Д.Сарангуа	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	П.Баянсан	Цалин, урамшууллын хорооны гишүүн
Б.Сүх-Очир	Аудитын хорооны гишүүн	-	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	Б.Даажамба	Цалин, урамшууллын хорооны гишүүн

The logo of the Mongolian Stock Exchange is mounted on the wall. It features a stylized sun or moon symbol at the top, followed by a traditional Mongolian architectural element, possibly a gate or a part of a palace wall, with intricate carvings.

МОНГОЛЫН ХӨРӨНГИ
MONGOLIAN STOCK EXCH

ГОЛЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА АМЖИЛТТАЙ ЯВАГДАВ

“2015-2016 онд Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах тухай” УИХ-ын 70 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 100 хувь төрийн өмчит “Монгол Шуудан” компанийн нийт хувьцааны 34 хувь буюу 6.3 тэрбум төгрөгийн хувьцааг 2016.01.08-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгон амжилттай арилжааллаа. Хөрөнгө оруулагчдаас нийт 12.6 тэрбум төгрөг буюу нийлүүлэлтээсээ 2 дахин худалдан авах захиалга ирсэн нь цаашид төрийн өмчит бусад компанийн хувьчлалыг амжилттай явуулах бүрэн боломжтойг харуулж

байна.

Хөрөнгийн биржээр дамжуулан ийнхүү өмч хувьчлалуудыг хэрэгжүүлснээр хөрөнгийн зах зээлд олон улсын жишигт нийцсэн хувьцаат компани бий болох, улмаар хөрөнгийн захад итгэх итгэл нэмэгдэх, өмч хувьчлалын үйл явц ил тод, шударга хэрэгжиж, бодит үнэлгээндээ хүрч, үнэ цэнэ нь өсөх ач холбогдолтой юм. Харин компанийн түвшинд илүү оновчтой засаглал тогтож, санхүүгийн гүйцэтгэл улам сайжрах, санхүүгийн чадавх сайжрахын хэрээр ажилчдын цалин хөлс, урамшуулал нэмэгдэх зэрэг эерэг нөлөөтэй юм.



“МОНГОЛ-ЛОНДОНГИЙН БИЗНЕС ФОРУМ” ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Монголын хөрөнгийн бирж, Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтран 5 дахь жилдээ “Монгол-Лондонгийн бизнес форум”-ыг 2016 оны 4 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Энэхүү форумд Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Худалдаа Аж Үйлдвэрийн Яам, Англи-Монголын худалдааны танхим, олон улсын байгууллагууд, Монголын аж ахуйн нэгжүүд, хөрөнгийн зах зээл дээр

идэвхитэй үйл ажиллагаа явуулагч Монгол, Английн хөрөнгө оруулагчид, бизнесмэнүүд зэрэг нийт 120 гаруй төлөөлөлөгч оролцсон байна.

Форумын үеэр хоёр орны хөрөнгийн зах зээлийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх бодлогын талаар харилцан санал солилцож, Монголын талаас тэргүүлэх чиглэлийн салбар болон хэрэгжүүлэх нэн шаардлагатай төслүүдийн талаар танилцуулга хийгдсэн байна



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛААР Х.АЛТАЙГ ТОМИЛЛОО

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 2016/03 тоот тогтоолоор М.Болорыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, 2016/04 тоот тогтоолоор Х.Алтайг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр томиллоо.

Х.Алтайнь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлаар 2011-2014 оны хооронд ажиллаж байсан бөгөөд ажиллаж байх хугацаандаа хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчин болон дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх ажлыг хэрэгжүүлж ажилласан туршлагатай юм.



“MIT” СИСТЕМ КАСТОДИАН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИН АЖИЛЛАХАД БЭЛЭН БОЛЛОО

2016 оны 9 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржийн MIT Арилжааны цогц систем Кастодиан банкны үйл ажиллагааг дэмжин ажиллахад бэлэн боллоо. Одоогийн байдлаар Санхүүгийн Зохицуулах Хорооноос кастодианы үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан Голомт кастодиан банк, Хаан кастодиан банк,

Худалдаа хөгжлийн кастодиан банк нар “ҮЦТХТ” ТӨХХК-тай “Төвлөрсөн хадгаламжийн гишүүнчлэлийн гэрээ” байгуулаад байна. Ийнхүү кастодиан банк төвлөрсөн хадгаламжид өөрийн болон харилцагчийн дансуудыг нээж, харилцагчдын захиалгыг хүлээн авах нөхцөл бүрдлээ.





ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ


2016 оны эхний хагасын байдлаар дэлхийн эдийн засгийн өсөлт ихээхэн удаашралтай байсан бол сүүлийн хагас, ялангуяа IV улиралд бага зэрэг сэргэх төлөв ажиглагдсан ч, өмнөх оны өсөлтийн түвшинд хүрч чадсангүй. Тус онд дэлхийн эдийн засгийн өсөлт өмнөх оноос 0.3 нэгж хувиар бууран 3.1 хувьд хүрсэн. ОУВС-гийн шинжээчдийн төсөөллөөр цаашдаа дэлхийн эдийн засаг сэргэх төлөвтэй байгаа бөгөөд 2017 онд 3.5 хувь, 2018 онд 3.6 хувиар тус тус өснө гэж үзэж байна.

2010 онд 10 гаруй хувиар өсч байсан Хятадын эдийн засгийн өсөлт саармагжсаар 2016 онд 6.7 хувиар өссөн, АНУ-ын эдийн засаг хүлээснээс доогуур буюу 1.6 хувиар өссөний

зэрэгцээ 2016 оны 6 дугаар сард Их Британи дотооддоо бүх нийтийн санал асуулга явуулсны дүнд Европын холбооноос гарах шийдвэр гаргасан нь ийнхүү дэлхийн эдийн засгийн өсөлтийг удаашруулав.

Мөн дэлхийн эдийн засагт АНУ-ын сонгуулийн үр дүн томоохон савалгаа үүсгэлээ. 2016 оны 11 дүгээр сарын эхэн үе хүртэл хөгжиж буй улсуудын санхүүгийн зах зээлд төдийлөн өөрчлөлт ажиглагдаагүй бол үүнээс хойш буюу АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа хөгжиж буй улсуудын валютууд сулрав. Түүнчлэн, бондын зах зээлд өгөөж нэмэгдэн, ам.долларын ханш чангарч эхэлснээр хөгжиж буй улсуудын хөрөнгийн зах зээлд сөрөг нөлөө үзүүлэв.

Дүрслэл 1. Дэлхийн эдийн засгийн өсөлт




Эх сурвалж: Олон Улсын Валютын Сан

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2016 онд Хятад болон бусад томоохон импортлогч орнуудын эдийн засгийн өсөлт саармагжиж, голлох эрдэс бүтээгдэхүүний нийт эрэлт буурсан нь уул уурхайг түшиглэсэн, хөгжиж буй орнуудад томоохон хүндрэл учрууллаа. Мөн АНУ-ын Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн нь хөгжиж буй орнуудыг чиглэсэн хөрөнгө оруулалтын урсгалыг бууруулах нөлөө үзүүлэв. 2014 онд 7.8 хувь, 2015 онд 2.3

хувийн өсөлттэй байсан манай улсын эдийн засаг 2016 оны эхний 3 улиралд 1.6 хувийн бууралттай гарсан ч, IV улиралд сэргэж, оны эцсийн дүнгээр 1 хувийн өсөлттэй гарлаа. Эдийн засгийн бүтцээр нь авч үзвэл 2016 онд барилгын салбар 16 хувиар, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 1.8 хувиар тус тус агшсан бол тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар 14.8 хувиар, ХАА-н салбар 4.8 хувиар өссөн байна.

Дүрслэл 2. Монгол Улсын ДНБ



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Өсөлттэй салбарууд:

Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	14.8%
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	4.8%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	4.6%
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	6.3%
Урлаг, үзвэр, тоглоом наадам	6.0%

Бууралттай салбарууд:


Боловсруулах үйлдвэрлэл	-1.8%
Барилга	-15.9%
Бөөний болон жижиглэн худалдаа	-3.2%
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	-2.9%
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	-1.4%

Инфляци

2016 оны жилийн эцсийн байдлаар улсын хэрэглээний үнийн индекс 1.1 хувиар, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 0.5 хувиар тус тус өсчээ. Өмнөх онуудтай харьцуулахад нийт эдийн засгийн идэвхжил саарч, эдийн засаг хүндрэлтэй байгаагаас шалтгаалан нийтэрэлтхумигдсан нь үнийн түвшинг

нам дор байлгахад нөлөөллөө. Оны эхнээс 5 дугаар сар хүртэл үнийн түвшин тасралтгүй өссөөр инфляци 3.3 хувьд хүрсэн ч, 6 дугаар сараас эхлэн дифляци явагдсаар жилийн эцсийн байдлаар үнийн ерөнхий түвшин 1.1 хувийн өссөлттэй гарсан байна.

Дүрслэл 3. Үнийн ерөнхий түвшин



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо


ГАДААД СЕКТОР

Төлбөрийн тэнцэл

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2016 оны гүйцэтгэлээр 18 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 250 орчим сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна. Хөрөнгө санхүүгийн дансны ашиг өнгөрсөн оны жилийн эцсийн гүйцэтгэлээс 58 сая ам.доллараар буурсан хэдий ч, урсгал дансны алдагдал 412.0 сая ам.доллараар буурсан нь нийт тэнцэлд эерэгээр нөлөөлсөн байна.

Урсгал дансны алдагдал 2012 онд 5.4 орчим тэрбум ам.долларт хүрч байсан бол түүнээс хойш тасралтгүй буурсаар 2015 онд 948 сая ам.доллар хүрсэн. 2016 онд урсгал дансны алдагдал дахин буурч 700 орчим сая ам.долларт хүрээд байна. Урсгал дансны алдагдал жилээс жилд буурч байгаа нь гадаад валютын улсын нөөц болон төгрөгийн ханшинд ирэх дарамтыг бууруулж байна.

Дүрслэл 4. Төлбөрийн тэнцэл



Эх сурвалж: Монголбанк


Гадаад худалдааны тэнцэл

2016 оны эцсийн байдлаар гадаад худалдааны эргэлт 8,270 орчим сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 60 орчим сая ам.доллараар буурсан байна. Харин экспорт өнгөрсөн оны мөн үеэс 8.0 хувиар өсч, 4,804 сая ам.долларт хүрсэн бөгөөд гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл чулуун нүүрс, боловсруулаагүй болон хагас боловсруулсан алтны экспорт өссөн нь голлох нөлөө үзүүлжээ. Импорт 2015 оноос 10.8 хувиар буурч, 3,466 сая ам.долларт хүрсэн бөгөөд

гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл нефтийн бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт буурсан нь голлох нөлөө үзүүлжээ.

Импорт 10.8 хувиар буурч, экспорт 8.0 хувиар өссөн нь гадаад худалдаа тэнцвэржихэд эерэг нөлөө үзүүлж байгаа ч, гадаад худалдааны нийт эргэлт өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар агшсан нь төсвийн орлого бүрдэлт, цаашлаад эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Дүрслэл 5. Гадаад худалдааны тэнцэл



Эх сурвалж: Монголбанк


Гадаадын хөрөнгө оруулалтын позиц

Гадаад, дотоод эдийн засгийн тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалан 2014 оноос хойш огцом буурсан Монгол Улсад орох гадаадын шууд хөрөнгө оруулалтанд 2016 онд дорвитой өсөлт ажиглагдсангүй. Мөн томоохон компаниудын хөрөнгө оруулагчаас авсан зээлийн эргэн төлөлт хийгдэж хөрөнгө оруулалтын гарах урсгал нэмэгдснээр гадаадын шууд хөрөнгө оруулалт /цэвэр дүнгээр/ огцом буурч 2016 оны гүйцэтгэлээр -3,699.5 сая ам.долларт

хүрэв. Өөрөөр хэлбэл 2015 оны жилийн эцсийн байдлаар 16,680 орчим сая ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт Монгол Улсын эдийн засагт эргэлдэж байсан бол 2016 оны эцэст энэхүү тоо 12,980 сая ам.доллар болж буурчээ.

Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш 2016 оны 12 дугаар сард 2482.6 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 24.4 хувиар суларчээ.

Дүрслэл 6. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц



Эх сурвалж: Монголбанк



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ




САНХҮҮГИЙН САЛБАРЫН БҮТЭЦ

Санхүүгийн салбарт эргэлдэж буй нийт активын 90 гаруй хувийг арилжааны банкны актив эзэлж байна. 2016 оны жилийн эцсийн байдлаар арилжааны банкуудын нийт актив 25.3 их наяд төгрөгт хүрээд байгаа бол үнэт цаасны зах зээлийн

үнэлгээ 1,474 тэрбум төгрөг, ББСБ-уудын нийт актив 787 тэрбум төгрөг, даатгалын компаниудын актив 208 тэрбум төгрөг, хадгаламж, зээлийн хоршоодын нийт актив 113 тэрбум төгрөгөөр тус тус хэмжигдэж байна.

Дүрслэл 7. Санхүүгийн зах зээлийн бүтэц



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо

Арилжааны банк

2016 оны эцсийн байдлаар Монгол Улсад нийт 14 банк 1492 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Банкны салбарын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.7 хувиар буюу 3.8 их наяд төгрөгөөр өсч 25.3 их наяд төгрөгт хүрчээ. Нийт активын бүтцийг авч үзвэл 48.7 хувь нь зээл, 11.5 хувь нь банкны нөөц, 13.8 хувь нь Засгийн газрын үнэт цаас, 2.3 хувь нь Төв банкны үнэт цаас, үлдэх 23.7 хувь нь бусад хөрөнгө байна.

Даатгал

2016 оны жилийн эцсийн байдлаар даатгалын салбарт Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй 17 даатгалын компани, 40 даатгалын зуучлагч компани, 31 даатгалын хохирол үнэлэгч компани болон даатгалын компанийн 242 салбар, 10 төлөөлөгчийн газар, даатгалын зуучлагч компанийн 208 салбар, даатгалын хохирол үнэлэгч компанийн 50 салбар, 2 төлөөлөгчийн газар тус тус үйл ажиллагаа явуулж байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ оны эцсийн байдлаар 208.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 35.2 тэрбум төгрөгөөр буюу 20.3 хувиар өссөн байна.

Банк бус санхүүгийн байгууллага

2016 оны эцсийн байдлаар нийт 518 Банк бус санхүүгийн байгууллага Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна. Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 787.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 26.3 хувиар буюу 163.9 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Активын бүтцийн хувьд 95.8 хувийг эргэлтийн хөрөнгө, 55.4 хувийг зээл, 30.9 хувийг мөнгөн хөрөнгө тус тус эзэлж байна.

Хадгаламж, зээлийн хоршоо

2016 онд Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх 34 тусгай зөвшөөрөл шинээр олгож, 7 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор нийт 280 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Тус онд хадгаламж, зээлийн хоршоодын нийт активын хэмжээ өнгөрсөн оны жилийн эцсээс 15.8 хувиар өсч, 113.1 тэрбум төгрөгт хүрээд байгаа бол нийт активын 74.9 хувийг зээлийн багц эзэлж байна.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК

Банкнаас бусад санхүүгийн салбар болох үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн Зохицуулах Хороо гүйцэтгэж байна. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь Монгол Улсад үнэт цаасны арилжааг зохион байгуулж буй байгууллага

бөгөөд үнэт цаасны зах зээл дээр хөрөнгө оруулагч нарт 58 гишүүн үнэт цаасны компаниар зуучлуулан 227 хувьцаат компанийн хувьцаа (үүнээс 100% төрийн өмчит хувьцаат компани-19), Монголын Улсын Засгийн газрын бонд, компанийн бонд гэсэн үнэт цаасуудыг олон улсын стандартад нийцсэн бүртгэл, төлбөр тооцоо, арилжааны системээр дамжуулан санал болгон арилжаалж байна.

Зах зээлийн оролцогч мэргэжлийн байгууллагууд

1991 онд Монголын хөрөнгийн биржийг үүсгэн байгуулж байсан бол 1994 онд Монгол улсын “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийг анхлан баталж улмаар 2002, 2013 онд “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийг шинэчлэн баталснаар хөрөнгийн зах зээлийн дэд бүтэц тодорхойлогдсон байдаг. Анх Монголын хөрөнгийн

биржийн бүрэлдэхүүнд “Төлбөр Тооцоо Хадгаламжийн Алба” нэртэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан алба Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 72 тоот тогтоолоор “Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК хэмээх бие даасан байгууллага болон өргөжиж үнэт цаасны бүртгэл,



хадгаламж болон үнэт цаасны төлбөр тооцооны үйлчилгээг эрхлэн гүйцэтгэж ирсэн билээ. 2016 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Засгийн газрын 147 тоот тогтоолын дагуу “Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-ийг “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК болон “Арилжааны Төлбөр Тооцоо” ХХК болгон хувааж, өөрчлөн зохион байгууллаа.

“Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК нь үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасны өмчлөх эрхийг

шилжүүлэх, биржийн бус арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэх, төвлөрсөн хадгаламж дах мэдээллийн баазыг өргөтгөх, олон улсын стандартын дагуу кастодион үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэж байна. Харин “Арилжааны Төлбөр Тооцоо” ХХК нь үнэт цаасны арилжааны дараах төлбөр, тооцоог шуурхай, эрсдэлгүй, найдвартай гүйцэтгэж, олон улсын жишигт нийцсэн төлбөр, тооцоо болон эрсдлийн удирдлагын тогтолцоог бий болгохыг зорин ажиллаж байна.

1. **Арилжаа эрхлэх байгууллага:** “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК
2. **Хадгаламжийн байгууллага:** “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК
3. **Төлбөр тооцооны байгууллага:** “Арилжааны төлбөр тооцоо” ТӨХХК
4. **Кастодиан банк:** Хаан банк, Худалдаа хөгжлийн Банк, Голомт банк
5. **Төлбөр гүйцэтгэх банк:** Хаан банк, ХАС банк, Худалдаа Хөгжлийн банк, Голомт банк
6. **Монголын хөрөнгийн биржийн гишүүн компани:** 58 гишүүн үнэт цаасны компани (андеррайтер 26 компани)
7. **Үнэт цаас гаргагч:** 227 хувьцаат компани, Монголын Улсын Засгийн газар
8. **Хөрөнгө оруулалтын менежментийн компани:** 13 компани

Үнэт цаасны бүртгэл

Хувьцааны бүртгэл

Монголын хөрөнгийн биржид 2016 оны 12-р сарын 31-ний байдлаар 227 ХК бүртгэлтэй байгаагаас 8.3% буюу 19 ХК нь 100 хувь төрийн өмчит, 6.6% буюу 15 ХК нь төрийн өмчийн оролцоотой, 85.0% буюу 193 ХК нь бүрэн хувьчлагдсан компани байна. Харин бүртгэлтэй үнэт цаасны хувьд нийт 8 тэрбум ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагаас 48.7% буюу 3.97 тэрбум ширхэг нь төрийн мэдлийн, 51.3% буюу 4.02 тэрбум ширхэг нь хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувьцаа байна.

Шинээр бүртгэгдсэн компаниуд: "Ай Түүлс" ХК

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 1 дугаар сарын 29-ний 20 дугаар тогтоол, Монголын хөрөнгийн биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ыг тус тус үндэслэн 2016 оны 3 дугаар сарын 03-ны өдөр "Ай Түүлс" ХК-ийн нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 4,324,263 ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржийн хувьцааны бүртгэлийн II ангилалд бүртгэн авлаа.

Хүснэгт 1. Нэмэлт хувьцаа гаргасан компаниуд

№	Компанийн нэр	Хувьцааны тоо ширхэг
1	"Монголын хөрөнгийн бирж" ХК	200,162,912
2	"Улаанбаатар дулааны сүлжээ" ХК	853,084,673
3	"Даваанбулаг" ХК	1,788,500
4	"Стандарт агрикалчер групп" ХК	13,599,265
5	"Евроазиа капитал холдинг" ХК	50,000,000
6	"Багануур" ХК	9,870,287

Хүснэгт 2. Бүртгэлээс хасагдсан компаниуд

№	Компанийн нэр	Хувьцааны тоо ширхэг
1	"Ган тээрэм" ХК	296,504
2	"Дорнод хүнс" ХК	388,719
3	"Аэрогеодези" ХК	3,806,767
4	"Шинэчлэл инвест" ХК	193,461
5	"Буудайн цацал" ХК	72,076
6	"Монсав" ХК	105,000
7	"Хөтөлийн цемент шохой" ХК	119,452,690
8	"Уран барилга" ХК	160,120
9	"Ай түүлс" ХК	4,324,263

Хүснэгт 3. Бүртгэлд өөрчлөлт орсон компаниуд

№	Компанийн нэр	Өөрчлөлт
1	"Сүү" ХК	Үнэт цаас хуваасан
2	"АПУ" ХК	Үнэт цаас хуваасан
3	"УБ БҮК" ХК	Үнэт цаас хуваасан
4	"Дулааны II цахилгаан станц" ХК	Үнэт цаас хуваасан
5	"Дархан зочид буудал" ХК	Үнэт цаас хуваасан
6	"Зоос гоёл" ХК	Үнэт цаас нэгтгэсэн
7	"Дижитал каталист" ХК	Оноосон нэрээ өөрчилж, "Люкс Занаду групп" ХК болсон
8	"ХААБЗ" ХК	Оноосон нэрээ өөрчилж, "Хүннү Менежмент" ХК болсон
9	"Шимтлэг" ХК	Оноосон нэрээ өөрчилж, "Хар Хорум Пропертийс" ХК болсон
10	"Жавхлант хараа" ХК	Оноосон нэрээ өөрчилж, Е-Моние" ХК болсон
11	"Арилжаа импекс" ХК	Оноосон нэрээ өөрчилж, "Стандарт ноос" ХК болсон
12	"Жаргалант үйлс" ХК	Оноосон нэрээ өөрчилж, "Ногоон хөгжил үндэсний нэгдэл" ХК болсон
13	"Газар сүлжмэл" ХК	Оноосон нэрээ өөрчилж, "Жуулчин дүти фрий" ХК болсон

Бүртгэлтэй үнэт цаасны тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад үнэт цаасны тоо ширхэг нь өмнөх оноос 2,196,366,743 ширхгээр буюу 37.8 хувиар өссөн нь 2016 онд 5 компани хувьцаагаа хувааж, 6 компани нэмж үнэт цаас бүртгүүлсэнтэй холбоотой юм.

Засгийн газрын бондын бүртгэл

2016 онд Засгийн газрын бондын бүртгэл долоо хоног бүр хийгдэж нийт 53 төрлийн нэрлэсэн үнээр нийт 305 тэрбум төгрөгийн Засгийн газрын бондыг бүртгэн арилжаалаад байна. Тайлангийн хугацаанд нийт 50

төрлийн Засгийн газрын бондын хугацаа дуусч, төлбөр бүрэн хийгдсэн тул бүртгэлээс хасав.

Компанийн бондын бүртгэл

Тайлант хугацаанд эрх бүхий байгууллага болон аж ахуйн нэгжүүдээс компанийн бонд бүртгүүлэх тухай шийдвэр гаргаж, хүсэлт ирүүлээгүй тул бонд шинээр болон нэмж бүртгэгдээгүй байна. Харин "Эрчим инженеринг" ХХК-иас гаргасан 50,000 ширхэг "Эрчим бонд"-ийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр нь бүрэн төлөгдсөн тул бүртгэлээс хасав.

Хүснэгт 4. Бүртгэлтэй үнэт цаасны тоон мэдээлэл /2016.12.31-ний байдлаар/


ҮЗҮҮЛЭЛТ	2015.12.31	2016.12.31	ӨӨРЧЛӨЛТ
Бүртгэлтэй компанийн тоо	235	227	-8
Үүнээс : Төрийн өмчит	37	34	-3
Хувийн өмчийн	198	193	-5
Бүртгэлтэй үнэт цаасны тоо / ширхэг /	5,804,676,657	8,001,043,400	2,196,366,743
Үүнээс : Төрийн өмчид / ширхэг /	2,991,104,074	3,975,554,635	984,450,561
Хувийн өмчийн / ширхэг /	2,813,572,583	4,025,488,765	1,211,916,182
Үнэт цаас шинээр бүртгүүлсэн ХК	3	1	-2
Үүнээс: Төрийн өмчит ХК	0	0	
Хувийн өмчийн	2	1	-1
Шинээр бүртгүүлсэн үнэт цаасны тоо /ширхэг/	86,494,863	4,324,263	-82,170,600
Нэмж үнэт цаас гаргасан ХК	7	6	-1
Нэмж бүртгүүлсэн үнэт цаасны тоо /ширхэг/	720,770,405	1,128,505,637	407,735,232
Бүртгэлээс хасагдсан ХК	5	9	4
Хасагдсан үнэт цаасны тоо /ширхэг/	4,838,750	128,799,600	123,960,850
Үнэт цаас хэсэгчлэн хасагдсан компанийн тоо	1	1	0
Хэсэгчлэн хасагдсан үнэт цаасны тоо	61,147	24,871	36,276
Хувьцаа хуваасан		5	
Хувьцаа хувааснаар нэмэгдсэн хувьцааны тоо / ширхэг/		1,205,973,507	1,205,973,507
Хувьцаа нэгтгэсэн		1	
Хувьцаа нэгтгэснээр хасагдсан хувьцааны тоо / ширхэг/		3,741,906	3,741,906
Хувьцаа эзэмшигчдийн хурал зарласан ХК	183	153	-30
Ноогдол ашиг тараасан ХК	26	28	2
Санхүүгийн тайлан ирүүлсэн ХК	153	148	-5

Зах зээлийн үнэлгээ

2016 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 1474.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 211.7 тэрбум төгрөг буюу 16.8 хувиар өссөн байна. 2015 онд "МИК холдинг" ХК 1.6 сая ширхэг хувьцааг 19.5 тэрбум

төгрөгөөр, 2016 онд Монгол Шуудан ХК нийт хувьцааныхаа 34 хувь буюу 33.9 сая ширхэг хувьцааг 6.3 тэрбум төгрөгөөр тус тус олон нийтэд нээлттэй санал болгон арилжсан нь зах зээлийн үнэлгээ ийнхүү өсөхөд голлох нөлөө үзүүллээ.

Дүрслэл 8. Зах зээлийн үнэлгээ




Арилжаа

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 244 удаагийн арилжаагаар 126 компанийн 93.7 сая ширхэг хувьцааг 49.0 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаагаар 3.1 сая ширхэг үнэт цаасыг 280.4 тэрбум төгрөгөөр, хоёрдогч зах зээлийн арилжаагаар

196.4 мянган ширхэг үнэт цаасыг 19.2 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 348.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Нийт гүйлгээний үнийн дүнгийн 14.1 хувийг хувьцааны арилжаа, 85.9 хувийг ЗГҮЦ-ны арилжаа тус тус эзэлж байна.

Дүрслэл 9. Арилжааны үнийн дүн




Хувьцааны арилжаа

2015 оны 4 дүгээр улиралд “МИК Холдинг” ХК-ийн 1.6 сая ширхэг хувьцааг 19.5 тэрбум төгрөгөөр арилжсан бол 2016 он гарснаар 1 дүгээр сард “Монгол шуудан” ХК-ийн үнэт цаасны 34 хувь буюу 33.9 сая ширхэг хувьцааг 6.3 тэрбум төгрөгөөр олон нийтэд санал болгон арилжсан байна.

2016 онд 49 тэрбумын хувьцааны арилжаа зохион байгуулсан нь

өнгөрсөн оны хувьцааны арилжаанаас 18.5 тэрбумаар буюу 60 орчим хувиар өссөн байна. Тайлант хугацаанд нийт 244 удаагийн арилжаагаар 126 компанийн 93.7 сая ширхэг хувьцааг 49.0 тэрбум төгрөгөөр арилжаалсны 69.6 хувь буюу 34.1 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, үлдэх 30.4 хувь буюу 14.9 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа тус тус бүрдүүлж байна.

Дүрслэл 10. Хувьцааны арилжааны үнийн дүн



Хүснэгт 5. Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

№	ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ	ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	АРИЛЖИГДСАН ТОО ШИРХЭГ	ҮНИЙН ДҮН
1	МИК ХОЛДИНГ	252,653,704,000	2,447,212	28,474,673,180
2	МОНГОЛ ШУУДАН ХК	33,845,421,329	13,913,002	4,109,167,038
3	ГАЗАР СҮЛЖМЭЛ	2,967,434,800	47,412	2,631,871,544
4	АПУ	294,342,724,940	2,137,562	2,302,534,402
5	ТАВАН ТОЛГОЙ	142,775,357,200	857,030	1,002,455,061
6	ГОВЬ	79,181,418,750	59,298	514,055,540
7	СҮҮ	44,087,040,000	1,699,264	449,060,857
8	МЕРЕКС	3,900,300,000	31,699,509	344,647,947
9	ТАЛХ ЧИХЭР	18,559,735,390	14,672	266,529,790
10	МОНИТ БУЛИГААР	3,481,844,400	146,615	264,866,400
11	ЦАГААН ТОЛГОЙ	398,926,800	56,034	214,644,745
12	ДАРХАН НЭХИЙ	21,556,840,500	9,950	185,152,650
13	СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП	231,164,872	1,041,952	147,960,778
14	ДОРНОД ХУДАЛДАА	739,690,000	14,748	147,480,000
15	РЕМИКОН	4,878,126,768	2,069,099	109,016,526

Хүснэгт 6. Ханшийн өсөлттэй үнэт цаас

№	ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ	12/31/2015	12/31/2016	ӨӨРЧЛӨЛТ /%/
1	ТЕХНИКИМПОРТ	1,605.00	6,125.00	281.62
2	СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП	46.44	142.01	205.79
3	МОНГОЛ ШУУДАН ХК	185.00	339.86	83.71
4	Е-МОНИЕ	151.00	264.07	74.88
5	АДУУНЧУЛУУН	1,200.00	1,800.00	50.00
6	ГЕРМЕС ЦЕНТР	122.62	169.90	38.56
7	СҮҮ	98.00	128.16	30.78
8	МАТЕРИАЛИМПЕКС	7,005.00	9,000.00	28.48
9	МОНИНЖБАР	135.00	172.00	27.41
10	ТАХЬ КО	16,990.00	21,600.00	27.13
11	ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС	315.00	400.00	26.98
12	УЛААН САН	1,592.00	2,000.00	25.63
13	НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ	1,200.00	1,450.00	20.83
14	ГОВЬ	8,480.00	10,150.00	19.69
15	СОР	1,589.00	1,899.00	19.51

ЗГҮЦ-ны арилжаа

2014 оны 11 дүгээр сараас эхлэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аар Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаас арилжигдаж эхэлсэн. Үүнээс хойш нийт 826.9 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 8.8 сая ширхэг үнэт цаас анхдагч зах зээл дээр арилжигдаад байна.

Анхдагч зах зээлийн арилжаа:

2016 онд нийт 31 удаагийн ЗГҮЦ-ны арилжаагаар 3.1 сая ширхэг үнэт цаасыг 280.4 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Тайлант хугацаанд анхдагч зах зээл дээр нийт 280.4 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжигдсанаас 12 долоо хоногтой үнэт цаас нийт арилжааны 30.3 хувийг, 28 долоо хоногтой үнэт цаас 31 хувь, 39 долоо хоногтой үнэт цаас 22.9 хувь, 52 долоо хоногтой үнэт цаас 13.3 хувь, 2 болон 3 жилийн урт хугацаатай үнэт цаас 1.8 хувийг тус тус эзэлж байна.

Хоёрдогч зах зээлийн арилжаа:

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр нээсэн бөгөөд тайлант хугацаанд нийт 196.4 мянган ширхэг



үнэт цаас 19.2 тэрбум төгрөгөөр арилжигдсан.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаанд “Новел инвестмент”, “Дэү секьюритиз”, “Голомт секьюритиз”, “БиДиСек”, “Стандарт инвестмент”, “Ард капитал групп” зэрэг ҮЦК-иуд идэвхитэй оролцсон байна.

Монголын хөрөнгийн бирж дээр арилжигдаж буй ЗГҮЦ-ыг хүүгийн түвшин болон арилжигдсан хэмжээгээр нь авч үзвэл дараах байдалтай байна.

Дүрслэл 11. 12 долоо хоногийн хугацаатай ЗГҮЦ




Дүрслэл 12. 28 долоо хоногийн хугацаатай ЗГҮЦ




Дүрслэл 13. 39 долоо хоногийн хугацаатай ЗГҮЦ




Дүрслэл 14. 52 долоо хоногийн хугацаатай ЗГҮЦ



Дүрслэл 15. 156 долоо хоногийн хугацаатай ЗГҮЦ



Дүрслэл 16. Өгөөжийн муруй /2016-12-31/



Зах зээлийн индексүүд

“ТОП-20” индекс:

Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 12939.50 нэгж, доод үзүүлэлт 10485.71 нэгж, дундаж үзүүлэлт 11550.09 нэгж байна. ТОП-20 индексийг өмнөх оны эцэстэй харьцуулахад 441.53 нэгжээр буюу 3.4 хувиар буурч, 12456.06 нэгж болсон байна.

MSE ALL индекс

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн MSE ALL индексийг албан ёсоор тооцож эхлээд байгаа билээ. Тайлант хугацаанд MSE ALL индексийн дээд үзүүлэлт нь 894.94 нэгж, доод үзүүлэлт нь 761.16 нэгж, дундаж үзүүлэлт нь 827.17 нэгж байна. MSE ALL индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.64 нэгжээр буюу 3.9 хувиар буурч, 861.24 нэгж болсон байна.

Дүрслэл 17. “ТОП-20” индекс



Дүрслэл 18. “MSE ALL” индекс



Гишүүн үнэт цаасны компаниуд

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн нийт 58 гишүүн үнэт цаасны компани зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр компаниудын 24 нь андеррайтерийн, 14 нь хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.



Хүснэгт 7. Гишүүн ҮЦК /Арилжааны идэвхээр эрэмбэлсэн/

Д/Д	СИМБОЛ	ҮЦК-ИЙН НЭР	ХАЯГ	УТАСНЫ ДУГААР	АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН
1	BDSC	БиДиСек ХК	УБ, СБД, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1 байр,	321763, 313108, 323411	136,222,532,165
2	NOVL	Новел инвестмент ХХК	СБД, 6-р хороо, Их Тойруу-49, Өег-Тулга компанийн байр 304 тоот	70121616	66,866,112,221
3	TDB	Ти Ди Би Капитал ХХК	УБ, ЧД, Жуулчны гудамж, Бага тойруу 12, Худалдаа хөгжлийн банкны төв байрны урд	311914, 70100261	63,034,099,504
4	TNGR	Тэнгэр капитал ХХК	УБ хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъяангүнийн гудамж ICC tower буюу /International Commercial Center/, 16 давхар.	70110637, 99087673	46,254,974,152
5	MNET	Ард секюритиз ХХК	УБ, СБД, Алтангэрэлийн гудамж, Сити центр - 403 тоот	321899	21,149,161,258
6	MSEC	Монсек ХХК	Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Орон зай төвийн 701 тоот	70153090, 91918840	18,946,215,625
7	BZIN	Дэу Секьюритис Монгол	УБ, СБД, 1-р хороо, Блюскай тауэр, 406 тоот	70110802, 70110803	16,260,414,965
8	GLMT	Голомт секюритиз ХХК	Монгол улс, Улаанбаатар-210644, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 12/1, Ди Би бийлдинг 401 тоот.	70121530	11,977,235,639
9	GAUL	Гаули ХХК	УБ, СБД, 1-р хороо Залуучуудын өргөн чөлөө, "Сонор плаза" төвийн оффисын 602 төв	70153300	11,799,719,445
10	STIN	Стандарт инвестмент ХХК	УБ хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж - 5/3	70114433,	11,525,623,457
11	SECP	СИКАП	ЧД, 1-р хороо, Баруун сэлбэ 5-3, Аризона төв, 2-21 тоот	70113980	2,626,546,348
12	MIBG	Эм Ай Би Жи ХХК	УБ, БГД, 16-р хороо, Амарсанаагийн гудамж, 12-1, Колорадо Бизнес төвийн 307 тоот	362620, 70110781	2,284,845,227
13	GNDX	Гендекс ХХК	УБ, СБД, 5-р хороо, 5-р хороолол, "Монгол даатгал-1" байрны 401 тоот	77336777, 99008777	1,656,019,995
14	ARD	Ард капитал групп ХХК	УБ, ЧД, 1-р хороо, Жуулчин-35, Дельта төвийн 503 тоот	310262	1,228,050,791
15	LFTI	Лайфтайм инвестмент ХХК	Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, "РОЯЛ" бизнес центр, 4 давхарт	70121418	783,853,425
16	NSEC	Нэйшнл сэкюритис ХХК	"УБ, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-4, Экспресс цамхаг, 3 давхар 301 тоот	331754, 94081189	607,240,025

Үнэт цаасны зах зээлийн тойм

Д/Д	СИМБОЛ	ҮЦК-ИЙН НЭР	ХАЯГ	УТАСНЫ ДУГААР	АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН
17	ZRGD	Зэргэд ХХК	УБ, БГД, 4-р хороо 5-р байр 24 тоот /Ханбүргэдэй төвийн дэргэд/	367609, 99297779	461,109,730
18	DELG	Дэлгэрхангай секюритиз ХХК	СБД, 8-р хороо, Хүүхэд залуучуудын соёлын төвийн зүүд хойд талд "GB плаза" төвийн 9 давхарт 902 тоот	99093482	423,268,008
19	BUMB	Бумбат-Алтай ХХК	УБ, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо Тэрх Цагаан Нуур ХХК 166 байр 402 тоот	99968989	408,395,559
20	ECM	Евразиа капитал монголиа ХХК	УБ, СБД, 1-р хороо, Олимпийн гудамж-16, Реженс, 3-н давхар, 314 тоот	77119799	393,063,940
21	UNDR	Өндөрхаан инвест ХХК	УБ, ЧД, Их тойруу 15-р гудамж "Аэрогеодези" ХК-ийн 3 давхар 301 тоот	329292, 99081660	350,925,903
22	APS	Азиа Пасифик секьюритис ХХК	УБ, СБД, 1-р хороо, Олимпийн гудамжийн 16/1 дүгээр байр 2 давхар 202 тоот	77300550, 77300880	255,404,618
23	SANR	Санар ХХК	УБ, БЗД-ийн 14-р хороо, Энх тайвны өргөн чөлөө "Монголын үндэсний алмаазан өрөмдлөг" ХХК-ийн 304 тоот	96669730; 99167312	165,558,525
24	TCHB	Тулгат чандмань баян ХХК	УБ, БГД, 2-р хороо Сөүлийн гудамж, УБТЗ-ын Төв эмнэлгийн захиргааны 208 тоот	50053322, 99137477	142,532,891
25	ARGB	Аргай бэст ХХК	УБ, ЧД, 2-р 40 мянгат 1-байр 33 тоот /Улсын их дэлгүүрийн ард	327026	142,173,810
26	TABO	Таван богд ХХК	"УБ, СБД, Сүхбаатарын талбай-2 Монголын үйлдвэрчдийн эвлэлийн байр 202 тоот Баян-Өлгий аймаг, Өлгий сум, төв талбай 5 баг 24 байр 3 тоот"	70422093, 99089224	124,597,441
27	DRBR	Дархан брокер ХХК	УБ,ЧД, Самбуугийн гудамж, Глобал бизнес центр, 4 давхар 406 тоот	99103719	118,234,589
28	CAPM	Капитал маркет корпораци ХХК	УБ, ЧД, Төмөрчний гудамж, Капитал банкны төв байрны баруун талд	330896 88003031	112,825,090
29	BULG	Булган брокер ХХК	УБ, СБД, 3-р хороо, 5-р хороолол, 9 дүгээр байр 33 тоот	324449, 99195114	101,308,491
30	ACE	АСЕ энд Т Капитал ХХК	УБ, СБД, 5-р хороо, Сөүлийн гудамж-37, Смарт билдинг, 301 тоот	70101044	74,836,110
31	BLMB	Блүмсбюри секюритиес ХХК	УБ, СБД, 8-р хороо, Бага тойруу, Самбуугийн гудамж, Блюмон центр, 801 тоот	91008288	69,379,151
32	GDSC	Гүүдсек ХХК	УБ, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Зайсан, Туул 1 хотхон, 2-р байр 05 тоот	331878, 88114876	62,872,454
33	MERG	Мэргэн санаа ХХК	УБ, БЗД,15-р хороолол 30-р байр 4-р орц 67 тоот /Баянцээл худалдааны төвийн хажууд/ УБ ХОТ БЗД 7-РХОРОО 15-Р ХОРООЛОЛ 30-67	451626, 99193878	58,792,122
34	ALTN	Алтан хоромсог ХХК	УБ, СБД, 8-р хороо, Ард санхүүгийн нэгдэлийн байр	11321899, 70078080	55,849,839
35	TTOL	Таван Толгойн Хишиг	УБ, СБД, Central tower, 903 тоот	77446161	52,772,807
36	MONG	Монгол секюритиес ХК	УБ, БЗД, 8 хороо, "22-р бааз" ХК-ийн байр 201 тоот	70120708, 86875387	48,077,005
37	MSDQ	Масдак ХХК	УБ, БЗД-ийн 5-р хороо "Асгат сервис" ХХК-ийн байр, 2-р давхар 219 тоот	99881008; 88186129	22,733,564

Д/Д	СИМБОЛ	ҮЦК-ИЙН НЭР	ХАЯГ	УТАСНЫ ДУГААР	АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН
38	MICC	Эм Ай Си Си ХХК	УБ, СБД, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал тауэр-912 тоот	"70112024 70112023 70112025"	21,974,023
39	GATR	Гацуурт трейд ХХК	УБ, БГД, 20-р хороо 2-р цахилгаан станцын баруун талд ГАЦУУРТ ХХК төв байр, 111 тоот	70113377	9,328,014
40	GDEV	Гранддевелопмент ХХК	УБ, БГД, Энх тайвны өргөн чөлөө-92, Юу Би платинум төвийн 4 давхарт 403 тоот	70149088; 99189270	7,132,711
41	ZGB	Зэт жи би ХХК	УБ, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, хуучин Сүхбаатар дүүргийн замын эсрэг талд "Голомт" банкны хажууд "Цэцээ Гүн" компанийн байр, 2 давхарт 201-б		5,380,355
42	SGC	Эс Жи Капитал ХХК	ЧД, 3-р хороо, Peace tower, 13-6 тоот	70119568	2,661,100
43	BSK	BLUE SKY	ЧД, 3-р хороо, "Тайваны соёлын төв" 207 тоот	70129060	2,075,241
44	GNN	ГОВИЙН НОЁН НУРУУ	"Говийн ноён нуруу" ХХК нь Өмнөговь аймгийн Даланзадгад хот дахь "Говийн оргил" төв		1,027,949
45	BATS	Батс ХХК	УБ, СБД, 1-р хороо, Олимпийн гудамж "Монгол 3000"	326042	-
46	BBSS	Би Би Эс Эс ХХК	УБ, СБД, 4-р хороо, 18 байр, 12 тоот	329713	-
47	BKHE	Бага хээр ХХК	Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг, Монголбанкны байр. 2-р давхарт		-
48	BLAC	Блэкстоун интернэйшнл ХХК	УБ, БЗД, 25-р хороо, Нарны зам 99А, Шинэ Дөл оффис, 404 тоот	88004829, 99842096	-
49	DCF	Ди Си Эф ХХК	УБ, ЧД, 4-р хороо, "Хүнсний нэг"-ийн ард 12-14 тоот	91162005	-
50	DGSN	Догсон ХХК	УБ, СБД, 6-р хороо, Их сургуулийн гудамж 10-б, 1 давхрын үйлчилгээний танхим		-
51	FCX	Эф Си Икс ХХК	"УБ, БГД, 19-р хороо, ""Монгол дизель"" ХК-ийн байр 62/3, Дорноговь аймаг: Монгол ардын намын байрны 2-р давхарт, Говьсүмбэр аймаг: Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн байр, 201 тоот, Говь-Алтай аймаг: Монголбанкны байр-305 тоот "	70100323; 99085490	-
52	FINL	Финанс линк групп ХХК	УБ, СБД, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-14210, Хасбуу плаза 301.	77117008	-
53	FRON	Фронтиер ХХК	УБ, СБД, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 17, Блю Скай центр-705 тоот	70119999, 70111991	-
54	HUN	Хүннү Эмпайр ХХК	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 12 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө, 5 дугаар байр, 59 тоот	99093069	-
55	ITR	Ай трейд ХХК	УБ, СБД, Амбассадор резиденс оффис, 301 тоот		-
56	MWTS	Эм Даблю Ти Эс ХХК	СБД, Оюутны гудамж 16/3 G&D center 105 тоот	70116030	-
57	PREV	Превалент ХХК	УБ, СБД, 6-р хороо, Бага тойруу, Залуучуудын өргөн чөлөө 2Б-д байрлах "ЭСК төв"-ийн 1-р давхар	329813	-
58	ZEUS	Зюс капитал ХХК	УБ, СБД 2-р хороо, 220-н мянгат, Болор бизнес төв, 203 тоот	331436, 329857	-

Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох сургалт

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь хөрөнгийн зах зээлд ажиллах мэргэжлийн боловсон хүчний эрэлт, хэрэгцээг хангах, сонирхсон иргэд, оюутан, сурагчдад үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох байнгын болон цаг үеийн асуудлаар сургалт, семинар зохион байгуулах зорилгоор үнэт цаасны зах зээлийн сургалтыг 2005 оноос хойш сар бүр тогтмол зохион байгуулж, сургалтандаа өнөөдрийн байдлаар 5000 гаруй иргэдийг (байгууллага, хамт олны захиалгыг оруулан) хамруулсан байна.

Манай сургалтанд санхүүгийн зах зээлд ажиллаж байгаа мэргэжилтнүүд болон их, дээд сургуулийн дадлага туршлагатай багш нар онол практик

хосолсон аргаар хичээл заадаг бөгөөд сургалтанд хамрагдагсад хөрөнгийн зах зээлийн үндсэн ойлголтууд, эрх зүйн зохицуулалт, зах зээлд тавих хяналт, хөрөнгө оруулагчдын эрх үүрэг, зах зээлд оролцогч байгууллагын үйл ажиллагаа, өөрт учрах эрсдлээ хэрхэн бууруулж болох талаар системтэй мэдлэг олж авснаар дотоод, гадаадын аль ч биржийн арилжаанд оролцох чадвартай болж төгсдөг.

2016 онд “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох сургалт” болон бусад захиалгат сургалтуудад нийт 150 гаруй аж ахуй нэгж, 600 гаруй иргэд хамрагдсан байна.





73 583	62	429	3 054	135	93 293	..	542	9 570
63	440	2 670	133	83 318	..	..	..	..
75 262	63	455	3 494	138	95 15	..	..	..
110	..	..	..	..	..	..	..	..
1 852	..	..	..	..	..	..	..	..

САНХҮҮГИЙН ТАЙЛАН



"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь 2015 болон 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайландаа олон улсад нэр хүнд бүхий "Кэй Пи Эм Жи Аудит" ХХК-аар хөндлөнгийн аудит хийлгэсэн болно.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Хүснэгт 8. Санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөгөөр/

	2016	2015
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	2,371,350	2,517,360
Биет бус хөрөнгө	1,763,683	2,255,655
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	61,864
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,135,033	4,834,879
Эргэлтийн хөрөнгө		
Бараа материал	13,000	44,499
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хэрэгсэл	1,000	197,257
Урьдчилгаа	2,370	2,572
Дансны авлага	148,493	380,450
Орлогын албан татварын авлага	8,988	10,372
Бусад авлага	-	164
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	515,142	587,863
Бусад эргэлтийн хөрөнгө	13,160	13,160
Эргэлтийн хөрөнгийн дүн	702,153	1,236,337
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,837,186	6,071,216
ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ		
Эздийн өмч		
Хувьцаат капитал	21,884,000	1,867,709
Бусад нөөц	458,684	20,475,388
Хүримтлагдсан алдагдал	(18,758,933)	(16,703,495)
Эздийн өмчийн дүн	3,583,751	5,639,602
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	1,177,047	419,540
Орлогын албан татварын өглөг	10,122	-
Бусад өглөг	66,266	12,074
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,253,435	431,614
ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ ДҮН	4,837,186	6,071,216

АШИГ АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

Хүснэгт 9. Дэлгэрэнгүй орлогын тайлан /мянган төгрөгөөр/

	2016	2015
Борлуулалтын орлого	1,176,149	1,536,265
Нийт орлого	1,176,149	1,536,265
Ерөнхий ба удирдлагын зардал	(1,918,224)	(1,371,086)
Миллениум Ай Ти системтэй холбоотой лиценз, сервис болон хорогдуулалтын зардал	(1,189,475)	(1,842,486)
Үйл ажиллагааны алдагдал	(1,931,550)	(1,677,307)
Санхүүгийн орлого	13,840	58,860
Санхүүгийн зардал	-	(241,047)
Гадаад валютын ханшийн цэвэр гарз	(137,540)	(364,601)
Татварын өмнөх алдагдал	(2,055,250)	(2,224,095)
Орлогын албан татварын зардал	(1,384)	(12,008)
Тайлант үеийн алдагдал	(2,056,634)	(2,236,103)

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Хүснэгт 10. Өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөгөөр/

	Хувьцаат капитал	Бусад нөөц	Хуримтлагдсан алдагдал	Нийт эздийн өмч
2014 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,867,709	478,064	(1,620,762)	725,011
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөөлөл	-	7,444,815	(12,846,630)	(5,401,815)
2015 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	1,867,709	7,922,879	(14,467,392)	(4,676,804)
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	(2,236,103)	(2,236,103)
Хувьцаа эзэмшигчийн оруулсан хувь нэмэр	-	12,552,509	-	12,552,509
2015 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,867,709	20,475,388	(16,703,495)	5,639,602
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	(2,056,634)	(2,056,634)
Хувьцаат капитал руу хийсэн хөрвүүлэлт	20,016,291	(20,016,291)	-	-
Бусад хөдөлгөөн	-	(413)	1,196	783
2016 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	21,884,000	458,684	(18,758,933)	3,583,751

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хүснэгт 11. Мөнгөн гүйлгээний тайлан-ШБ /мянган төгрөгөөр/

	2016	2015
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Тайлант үеийн алдагдал	(2,056,634)	(2,236,103)
Тохируулга:		
Элэгдэл ба хорогдол	665,281	739,088
Бусад эргэлтийн данснаас хасалт	61,864	-
Найдваргүй авлагын дансны нөөц	224,116	142,111
Бараа материалын хорогдлын нөөц	29,828	11,256
Орлогын албан татварын зардал	1,384	12,008
Ханшийн зөрөөний хэрэгжээгүй цэвэр гарз	137,540	364,190
Хүүгийн орлого	(13,840)	(58,860)
Хүүгийн зардал	-	241,047
Ажлын капиталын өөрчлөлтөөс өмнөх үйл ажиллагааны алдагдал	(950,461)	(785,263)
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт:		
Дансны болон бусад авлага	18,372	(1,400,039)
урьдчилгаа	-	109,963
Бараа материал	1,671	6,272
Дансны болон бусад өглөг	673,314	(3,353,001)
	(257,104)	(5,422,068)
Хүлээн авсан хүүгийн орлого	13,840	58,860
Төлсөн хүүгийн зардал	-	(133,195)
Төлсөн орлогын албан татвар	-	(26,258)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(243,264)	(5,522,661)

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хүснэгт 12. Мөнгөн гүйлгээний тайлан-ШБ (үргэлжлэл) /мянган төгрөгөөр/

	2016	2015
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(27,299)	(30,942)
Худалдан авсан биет бус хөрөнгө	-	(3,750)
Засгийн газрын үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	-	(1,396,068)
Засгийн газрын үнэт цаасны буцаан төлөлт	196,257	1,198,811
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	168,958	(231,949)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хувьцаа эзэмшигчээс оруулсан хувь нэмэр	-	9,520,604
Урт хугацаат зээлийн эргэн төлөлт	-	(3,294,900)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	6,225,704
Ханшийн өөрчлөлтийн нөлөөлөл	1,585	1,738
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт	(72,721)	472,832
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	587,863	115,031
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	515,142	587,863

Монголын Хөрөнгийн Бирж



**Монгол Улс
Улаанбаатар хот 15160
Сүхбаатарын талбай-3
Монголын Хөрөнгийн Бирж**



+976 11-313747



+976 11-325170



info@mse.mn



www.mse.mn